



ДӨРВӨН УУЛ ХК

ДӨРВӨН УУЛ ХК-ИЙН 2020 ОНЫ ЖИЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН

Эрхэм хувьцаа эзэмшигчид та бүхний энэ өдрийн амар амгаланг айлтган мэндчилж байна.

2020 онд манай компани амжилтаа ахиулсан жил байсныг цохон тэмдэглэхэд таатай байна.

Манай компани 2020 онд 2 ажлын байр түрээслэгч байгууллага, 12 худалдан авагч байгууллагатай, 6 ажиллагсадтай, 5 нэр төрлийн хөзөр борлуулах үйл ажиллагаа явууллаа.

Одоо та бүхэнд 2020 онд тус компанийн хийж гүйцэтгэсэн ажлыг үйл ажиллагааны чиглэл тус бүрээр товч танилцуулъя.

Нэг : Санхүүгийн чиглэлээр :

“Дөрвөн Уул” ХК нь 2020 онд санхүүгийн тайлангаа Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Компанийн тухай хуульд заасны дагуу нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу тогтоосон хугацаанд гаргаж, санхүүгийн зохицуулах хорооны бүртгэлтэй аудитын байгууллагаар баталгаажуулан харьяа татварын албаар хянуулж, зохих байгууллагуудад хүргүүлэн МУ-ын хууль тогтоомжийг мөрдөн ажиллалаа.

Татвар, НДШ-ийн өр төлбөргүй байгууллага болох зорилтуудын хүрээнд:

НД-ийн байгууллагад 4769,8 мянган төгрөгийн шимтгэл төлж өргүй гарсан. Татварын байгууллагад 9009,1 мянган төгрөгийн татвар төлж 258,7 мянган төгрөгийн илүү төлөлттэй гарсан.

Өөрийн гэсэн орлоготой болж үйл ажиллагаа тогтмолжих, өргөжих төлөвтэй болсон зэрэг дэвшилт гарсан болно.

Тайлант онд борлуулалтын орлого өмнөх оноос 37,5 хувиар өсч үйл ажиллагааны зардлыг 13,4 хувиар бууруулж, ашигт ажиллагааны түвшинг 0,1 коэффициентээр өсгөсөн нь чанарын үзүүлэлт юм.

Эргэлтийн хөрөнгө өмнөх оны мөн үеэс 61,8 % буюу 34,664 мянган төгрөгөөр өссөн бөгөөд эргэлтийн бус хөрөнгөд төдийлөн өөрчлөлт ороогүй болно. Нийт өр төлбөрийн хувьд 5,9%-ийн өсөлттэй байгаа бөгөөд өмнөх оноос нэмэгдэж өсөөгүй тогтвортой байдалтай байна.

Санхүүгийн байдал

	2019	2020	Оны эхнээс
	<i>Гүйцэтгэл</i>	<i>Гүйцэтгэл</i>	
Эргэлтийн хөрөнгө	55,959.6	90,623.6	61.8%
Эргэлтийн бус хөрөнгө	490,018.4	477,421.5	
Нийт актив	545,978.0	568,045.1	
Өр төлбөр	570,019.2	603,873.4	5.9%
Эздийн өмч	-24,041.2	-35,828.3	
Нийт пассив	545,978.0	568,045.1	

Балансын бүтцийн хувьд эргэлтийн хөрөнгө өссөн эерэг өөрчлөлт байгаа бол эргэлтийн бус хөрөнгийн бүтэц төдийлөн өөрчлөгдөөгүй бөгөөд нийт өр төлбөрийн өсөлт тогтвортой байна.

Орлого үр дүн

	2019	2020
	<i>Гүйцэтгэл</i>	<i>Гүйцэтгэл</i>
Цэвэр борлуулалтын орлого	79,903.9	109,868.1
Борлуулсан бүтээгдэхүүний өртөг	31,711.6	43,507.4
Нийт ашиг		
Үйл ажиллагааны зардал	90,228	78,147.8
Үйл ажиллагааны ашиг		
Үйл ажиллагааны бус ашиг, алдагдал		
Татвар төлөхийн өмнөх ашиг	(42,035.7)	(11,787.1)
Татварын зардал		
Татварын дараах ашиг		

Хоёр: Борлуулалтын чиглэлээр :

1. Манай компани нь 2018 оноос. Сүлжээ дэлгүүрүүдэд хөзөр борлуулах ажлыг амжилттай хэрэгжүүлж байна. ДӨРВӨН УУЛ ХК-нь хөзөр борлуулалтын 12 ан ахуйн нэгжтэй хамтран ажилладаг. Энэ нь өмнөх оноос 4 нэгжээр нэмэгдүүлсэн бөгөөд 2020 оны хөзөр борлуулалтын орлого 87273,5 мянган төгрөг болж өссөн.
2. Ажлын байр түрээсийн 1 иргэн, 1 ААН-тэй хамтран ажиллаж байгаа боловч COVID19 цар тахлын улмаас түрээсийн байгууллагын үйл ажиллагаа зогсонги байдалд орж түрээсийн орлого өмнөх оноос буурсан үзүүлэлттэй байна.

Гурав: Хүний нөөцийн чиглэлээр :

“Дөрвөн Уул” ХК нь хүний нөөцийн хувьд тогтвортой ажилтан, албан хаагчидтай болж байнгийн 6 ажилтантай ажиллаж байна.

Дөрөв: Бүтээн байгуулалтын талаар :

Дулааны асуудлаа шийдэхийн тулд төвийн шугамтай холбох техникийн нөхцөл авсан боловч хөрөнгө санхүүгийн байдлаас болж зогсонги байдалтай байгаа болно.

Тав: Ногдол ашгийн талаарх мэдээлэл:

Компанийн тухай хуулийн 46.8 дах хэсэгт заасан шалгуурыг хангаагүй буюу тайлант хугацаанд алдагдалтай ажилласан тул ногдол ашиг хуваарилахгүй байхаар 2021 оны 2 дугаар сарын 26-ны өдрийн Төлөөлөн удирдах зөвлөлийн хурлаар шийдвэрлэсэн.

2021 ОНЫ ТӨЛӨВЛӨГӨӨ

1. Борлуулалтын нэгжээ нэмэгдүүлэх /супермаркетуудын тоог нэмэгдүүлэх
2. Бэлтгэн нийлүүлэгчээс авах бараа бүтээгдэхүүний төрөл, тоог олшруулан бараа бүтээгдэхүүнийг тоог 3-5 төрлөөр нэмэгдүүлэх
3. Сошиалаар мэдээлэл түгээлтийг идэвхжүүлэх, онлайн захиалгаар бараа түгээлтийг хийх

**Анхаарал тавьсан “ДӨРВӨН УУЛ ” ХК-ийн хүндэт хувьцаа эзэмшигч
ТА БҮХЭНД БАЯРЛАЛАА.**